



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны 02 дугаар сарын 02-ны өдөр

Төрийн ордон

Улаанбаатар хот

### НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “60 нас хүрсэн” гэсний дараа “эрэгтэй, 55 нас хүрсэн эмэгтэй” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.**Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “55” гэснийг “50” гэж, мөн зүйлийн 3 дахь хэсгийн 1 дэх заалтын “55 нас хүрсэн бол” гэснийг “50 нас хүрсэн бол өөрийн хүсэлтээр” гэж, мөн хэсгийн 2 дахь заалтын “эрэгтэй 55 нас” гэснийг “эрэгтэй 50 нас” гэж, “эмэгтэй 50 нас хүрсэн бол” гэснийг “эмэгтэй 45 нас хүрсэн бол тус тус өөрийн хүсэлтээр” гэж, 22 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсгийн “5” гэснийг “7” гэж, мөн зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтын “таван” гэснийг “долоон” гэж, 2 дахь заалтын “таван” гэснийг “долоон” гэж, “60-д хуваана” гэснийг “84-д хуваана.” гэж тус тус өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг 2018 оны 02 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

М.ЭНХБОЛД



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр

Төрийн ордон

Улаанбаатар хот

### **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** 2017 оны 02 дугаар сарын 02-ны өдөр баталсан Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 5 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**“5 дугаар зүйл.** Энэ хуулийн 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг болон 2 дугаар зүйл, 3 дугаар зүйл, 4 дүгээр зүйлийг 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс, 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн тус тус дагаж мөрдөнө.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА**

**М.ЭНХБОЛД**



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр

Төрийн ордон

Улаанбаатар хот

### **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “60 нас” гэснийг “65 нас” гэж, “55 нас” гэснийг “60 нас” гэж, “эмэгтэй” гэснийг “даатгуулагч” гэж, мөн зүйлийн 2 дахь хэсгийн “50 нас” гэснийг “55 нас” гэж, мөн зүйлийн 5 дахь хэсгийн “60 нас хүрсэн эрэгтэй, 55 нас хүрсэн эмэгтэй” гэснийг “энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан насанд хүрсэн даатгуулагч” гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА**

**М.ЭНХБОЛД**



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 02 дугаар сарын 02-ны өдөр

Төрийн ордон

Улаанбаатар хот

### НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараахь хэсэг, заалт нэмсүгэй:

#### **1/3 дугаар зүйлийн 5, 6 дахь хэсэг:**

“5. Төрүүлсэн болон гурав хүртэл настайд нь үрчлэн авч зургаан нас хүртэл хүүхдээ өсгөсөн эхийн нийгмийн даатгалын шимтгэл төлсөн нийт хугацаан дээр төрүүлсэн болон үрчлэн авсан хүүхэд бүрийн тоогоор нэг жил зургаан сарыг нэмж тооцно.

6. Энэ зүйлийн 3 дахь хэсгийн 3 дахь заалтад заасан хугацааны шимтгэлийг дараахь журмаар төлнө:

1/холбогдох хууль тогтоомж, хамтын гэрээ хэлэлцээрт заасны дагуу ажил олгогч нь;

2/нийгмийн даатгалд сайн дураараа даатгуулсан эх энэ хуулийн 19<sup>1</sup> дүгээр зүйлд заасан тэтгэмж авах эрх үүссэн бол тэтгэмжийн даатгалын сангаас;

3/энэ хэсгийн 1 ба 2-т зааснаас бусад тохиолдолд эхийн төлбөл зохих шимтгэлийн 50 хувийг төрөөс, 50 хувийг эх өөрөө.”

#### **2/4 дүгээр зүйлийн 7 дахь хэсэг:**

“7. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 3.1.9-д заасан иргэн доор дурдсан болзол хангасан бол өндөр насны тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй:

1/нийт 20-иос доошгүй жил, үүнээс 15-аас доошгүй жил малчнаар ажиллаж тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн эрэгтэй 55 нас хүрсэн бол;

2/нийт 20-иос доошгүй жил, үүнээс 12 жил 6 сараас доошгүй жил малчнаар ажиллаж тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн эмэгтэй 50 нас хүрсэн бол.”

**2 дугаар зүйл.**Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 3 дахь заалт, 19<sup>2</sup> дугаар зүйлийн 1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**1/3 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 3 дахь заалт:**

“3/хүүхдээ гурван нас хүртэл асрах чөлөөтэй байсан хугацаа;”

**2/19<sup>2</sup> дугаар зүйлийн 1 дэх хэсэг:**

“1.Энэ хуулийн 19<sup>1</sup> дүгээр зүйлд заасан тэтгэмж авах эрх үүссэн эхэд тэтгэмжийн даатгалын шимтгэл төлсөн сүүлийн 12 сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дунджаас 100 хувиар тооцож 4 сарын хугацаанд жирэмсний болон амаржсаны тэтгэмж олгоно.

**3 дугаар зүйл.**Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн “хоёр сараар” гэснийг “зургаан сараар” гэж, 5 дахь хэсгийн дугаарыг “7” гэж өөрчилсүгэй.

**4 дүгээр зүйл.**Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 19<sup>1</sup> дүгээр зүйлийн 3 дахь хэсгээс “Энэ тохиолдолд уг эхийн чөлөөтэй байсан хугацааны хоёр удаагийн төрөлт хамаарагдана.” гэснийг, 19<sup>2</sup> дугаар зүйлийн 2 дахь хэсгийг тус тус хассугай.

**5 дугаар зүйл.**Энэ хуулийн 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг болон 2 дугаар зүйл, 3 дугаар зүйл, 4 дүгээр зүйлийг 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс, 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн тус тус дагаж мөрдөнө.

[/Энэ зүйлийг 2017 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА**

**М.ЭНХБОЛД**